



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар Б/51

Чингис хот

Д.Цэцэгсүрэнг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.5 дахь хэсэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5, 1.6, 2.1, 5.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн Д.Цэцэгсүрэнг ажлын зайлшгүй шаардлагаар Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор томилох болсон тул 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Нямдаваа Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Онончимэг Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн

Э.Ариунтунгалаг Нягтлан бодогч

Т.Бямбадулам Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Нярав

3. Д.Цэцэгсүрэнд холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР



231030173